

Түнш байгууллагууд

Үндэсний Олимпийн Хорооны онцлох тэмдэгийг

хэрэглэх стандарт

Нэг. Танилцуулга

Энэхүү стандартын зорилго нь Үндэсний Олимпийн Хороо өөрийн онцлох тэмдэгээ түнш байгууллагууддаа хэрэглүүлэхэд тавигдах шаардлага, хэрэглээг зохицуулахад оршино.

Олимпийн таван цагариг, олимп... үг хэллэг нь Олон Улсын олимпийн хорооны өмч тул аль ч улсын Үндэсний Олимпийн Хороо нь түнш байгууллагууддаа эдгээрийг хэрэглэх баталгаа өгөх боломжгүй.

Түүнчлэн Үндэсний Олимпийн Хорооны түнш байгууллагууд нь логог Олон Улсын Олимпийн Хороо, Олимпийн наадмын зохион байгуулах хорооноос гаргасан журмын хүрээнд хэрэглэнэ.

Хоёр. Үндэсний Олимпийн Хорооны эмблем

Тодорхойлолт

“Үндэсний Олимпийн Хорооны эмблем” гэж Олон Улсын Олимпийн Хороогоор батлагдсан олимпийн бэлэг тэмдгийг бусад элементтэй хослуулан бүтээсэн ямар нэгэн загварыг хэлнэ.

Олимпийн Хартийн 15 дугаар бүлэгт зааснаар Үндэсний Олимпийн Хорооны логог дараахи байдлаар тодорхойлно.”Олимпийн эмблем нь Олимпийн таван цагаригийг бусад элементүүдтэй хослон бүтээгдсэн байна. Олимпийн эмблемийн ямар ч загварыг ОУОХ-нд илгээж, түүний гүйцэтгэх зөвлөлөөр батлуулна. Гүйцэтгэх зөвлөлийн баталсан эмблемийг үйл ажиллагаандаа хэрэглэхийг зөвшөөрнө.”

Үндэсний Олимпийн Хорооны эмблем нь тухайн улсын Үндэсний Олимпийн Хороо болон Олимпийн багийг илэрхийлнэ.

Бүтэц

Үндэсний Олимпийн Хорооны эмблем нь гурван үндсэн хэсгээс бүрдэнэ.

- Олимпийн бэлэг тэмдэг /хоорондоо хэлхэлдсэн таван өнгийн цагариг/
- Үндэсний бэлэг тэмдэг эсвэл төрийн далбаа
- Үндэсний Олимпийн Хорооны нэр

Өнгө

Үндэсний Олимпийн Хорооны эмблем нь хэрэгцээнээсээ хамааран дор дурдсан 3 үндсэн хэлбэрийн өнгөний сонголттой байж болно.

1. Хар цагаан

2. Дан өнгөт

Дан өнгөт хувилбарын үед эмблем нь бүхэлдээ саарал, алтан, мөнгөн, боронз гэсэн албан ёсны өнгөний аль нэгээр бүтээгдсэн байна.

3. Бүтэн өнгөт

Энэ хэлбэрийн үед эмблемийн хэсэг бүр өөрийн үндсэн өнгөөр бүтэгдсэн байна.

Өнгөт хувилбарт хэрэглэх өнгийг Pantone системээр гаргана.



Олимпийн таван цагаригийн өнгөний код:

Цэнхэр 3005C

Шар 137C

Хар BlackC

Ногоон 355 C

Улаан 192 C

Дэвсгэр

Үндэсний Олимпийн Хорооны эмблем нь өнгийн дэвсгэртэй байхыг хориглоно. Таван цагаригийн бүх өнгийг тодруулах зорилгоор логоны дэвсгэр цагаан өнгөтэй байх шаардлагатай.

Үндэсний Олимпийн Хорооны эмблемийн хэмжээ нь хамгийн багадаа бүрэлдэхүүн хэсгүүд нь тус тусдаа танигдахаар хийгдсэн байвал зохино.

Тусгаарлах зурвас

Үндэсний Олимпийн Хорооны эмблем нь тусгаарлах талбайтай байх шаардлагатай. Энэхүү тусгаарлах зурвас нь бусад барааны тэмдэг, шошго нэртэй андуурагдах, холилдохоос сэргийлнэ.

Гурав. Үндэсний Олимпийн Хорооны түншүүдийн эмблем хэрэглэх ерөнхий нөхцөл

Үндэсний Олимпийн хороо нь дан болон нийлмэл гэсэн 2 ялгаатай хэлбэрийн загвар бүхий лого бүтээж, түншүүддээ ашиглуулж болно.

Нэг. Нийлмэл лого

Тодорхойлолт

Нийлмэл лого нь Үндэсний Олимпийн хорооны лого, түнш байгууллагын лого, эсвэл барааны тэмдэг, тодорхойлолт албан ёсны тодорхойлолт гэсэн 3 хэсгийг агуулсан байна. Үндэсний Олимпийн Хороо нь бүтээсэн нийлмэл логог маркетинг болон идэвхижүүлэлтийн арга хэмжээнд хэрэглэнэ.

Жишээ 1:



Бүтэц:

Нийлмэл лого нь дараахи элементүүдээс бүтнэ. Үүнд:

- Үндэсний Олимпийн Хорооны эмблем
- Түнш байгууллагын лого, эсвэл барааны тэмдэг
- Албан ёсны тодорхойлолт
- Эмблем, логог тусгаарлах зурвас

Үндэсний Олимпийн Хорооны эмблем болон түнш байгууллагын лого нь ижил хэмжээтэй байх шаардлагатай. Хэрэв түнш байгууллагын лого нь дүрмийн бус хэмжээ дүрс агуулсан байвал лого бүтээх үеийн тухайн тохиолдлоос хамаарч Үндэсний Олимпийн Хороо зөвшөөрөл олгож, баталгаажуулна.

Дан лого

Тодорхойлолт

Энэхүү лого нь Үндэсний Олимпийн Хорооны түнш байгууллагын хэрэглэх логоны өөр нэгэн хувилбар юм. Уг хувилбарын үед Үндэсний Олимпийн Хорооны болон түнш байгууллагын лого нь салангид байна. Дан логог маркетинг, урамшууллын үйл ажиллагаанд хэрэглэнэ.


Бүтэц

Дан лого нь дор дурдсан элементүүдээс бүрдэнэ.

- Үндэсний Олимпийн Хорооны эмблем
- Түнш байгууллагын тэмдэглэгээ
- Түнш байгууллагын лого

Үндэсний Олимпийн Хорооны лого болон түнш байгууллагын албан ёсны тэмдэглэгээ нь дээр доор байрласан 2 тэгш өнцөгт дотор байрлана.

Дээр нь байрласан тэгш өнцөгт дотор Үндэсний Олимпийн Хорооны лого байрлана. Харин доод талын тэгш өнцөгтөд түнш байгууллагын албан ёсны тэмдэглэгээ байна. Дан лого нь спонсорын үндсэн логотой ижил хэмжээтэй байна.



Дан логонд байх Үндэсний Олимпийн Хорооны болон түнш байгууллагын эмблем нь тус тусдаа тод ялгаран харагдахуйцаар хийгдсэн байна.

Түнш байгууллагын тэмдэглэгээ

Тодорхойлолт

“Түнш байгууллагын тэмдэглэгээ” нь ивээн тэтгэгч, нийлүүлэгч зэрэг Үндэсний Олимпын Хороо эсвэл Олимпын багтай хамтран ажиллаж буй хэлбэрийг заасан утгийг агуулна.

Бүтэц

“Түнш байгууллагын тэмдэглэгээ”-ний зорилго нь ивээн тэтгэгч, нийлүүлэгч болон Үндэсний Олимпын Хорооны харилцааны хэлбэрийг илэрхийлэх, сурталчлахад оршино. Тэмдэглэгээ нь Үндэсний Олимпын Хорооны эмблемийг хэрэглэх үед ивээн тэтгэгчид болон Үндэсний Олимпын Хорооны хамтын ажиллагааны харилцааны хамгаалалт болдог.

Түүнчлэн уг тэмдэглэгээ нь тухайн түнш байгууллагын хэрэглэгчид, үйлчлүүлэгчдэд ойлголт төрүүлэх ач холбогдолтой.

Түнш байгууллагын тэмдэглэгээ нь доорхи загвартай байна.

- /улсын нэр /-ын Олимпын Хорооны албан ёсны түнш
 - /улсын нэр /-ын Олимпын Хорооны албан ёсны бүтээгдэхүүн нийлүүлэгч
 - /улсын нэр /-ын Олимпын Хорооны албан ёсны бүтээгдэхүүн
 - /улсын нэр /-ын Олимпын Хорооны албан ёсны түнш
- оны Үндэсний олимпын багийн албан ёсны ивээн тэтгэгч